

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ,  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2025/137/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2025 он  
Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

**Тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

**Аудитор:** Х.Еркегүл  
Утас: 99040705  
Цахим хаяг: [erkhegulkh@audit.gov.mn](mailto:erkhegulkh@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2025.02.22 № 176  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
О.БАДАМСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас 16,756,033.7 мянган төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт, орон нутгийн төсвөөс 1,430,469.6 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авч, гүйцэтгэлээр 17,954,106.4 мянган төгрөгийг зарцуулж, 587,678.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж үйлчилгээний санхүүжилт өмнөх оноос 5,156,456.8 мянган төгрөгөөр өссөн, тогтмол зардлын санхүүжилт 1,430,469.6 орон нутгийн төсвөөс олгодог болсон өр төлбөрийн үлдэгдэл 2,178,494.6 буюу өмнөх оноос 138,061.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тус байгууллагад Эрүүл мэндийн яамнаас 599,135.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 17,594.2 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжиж ирсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 591,931.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс авлагыг 34,161.2 мянган төгрөг, өглөгийг 475,090.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгийг 51,680.5 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулав.

232502173

Албан хаагчид цалингийн нэмэгдэл, урамшуулал илүү олгосон 23,049.4 мянган төгрөг, түрээсийн авлага 7,950.5 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг 30,999.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүллээ.

Төлбөртэй үйлчилгээний орлогыг шалгахад бэлэн мөнгөөр орсон кассын орлогыг татварын тайлангийн и баримттай тулган шалгахад 7,489.8 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь 2024 оны 1-3 сард үйлчлүүлсэн иргэдэд олгосон орлогыг дутуу тушааж байсан эд хариуцагчийг шалгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 27-ны 01/131 албан бичгээр хуулийн байгууллагад шилжүүлсэн байгаа тул энэ асуудлыг аудитын дүнд оруулаагүй болно.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 9 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 88.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,972,836,908.35</b>	<b>1,852,423,249.01</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>9,911,845.00</b>	<b>598,073,031.12</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>9,911,845.00</b>	<b>598,073,031.12</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>9,911,845.00</b>	<b>598,073,031.12</b>
31211	Төрийн сангийн харилцах	9,911,845.00	598,073,031.12
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>980,079,252.00</b>	<b>206,266,349.17</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	42,626.17
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	980,079,252.00	206,223,723.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>982,845,811.35</b>	<b>1,048,083,868.72</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>702,629,226.65</b>	<b>725,324,397.02</b>
35110	Тусгай зориулалттай материал		2,300,000.00
35130	Эм боох материал	702,629,226.65	723,024,397.02
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>275,476,584.70</b>	<b>320,929,471.70</b>
35410	Бичиг хэргийн материал	11,882,500.00	17,710,150.00
35420	Аж ахуйн материал	59,375,985.00	62,957,535.00
35430	Сэлбэг хэрэгсэл	90,836,527.10	110,321,032.10
35440	Түлш, шатах тослох материал	196,560.00	113,400.00
35450	Барилгын засварын материал	34,967,150.00	44,142,472.00
35460	Хүнсний материал	1,801,280.00	8,478,300.00
35470	Бусад хангамжийн материал	76,416,582.60	77,206,582.60
35600	Мал амьтад	4,740,000.00	1,830,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,453,043,133.29</b>	<b>25,251,429,849.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>26,453,043,133.29</b>	<b>25,251,429,849.08</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>25,583,868,204.21</b>	<b>24,383,318,445.02</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,400,979,312.00	21,400,979,312.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,592,571,930.58)	(1,963,991,157.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	560,117,549.97	1,086,682,062.72
39204	Хуримтлагдсан элэгдэл	(82,805,512.74)	(186,469,212.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,115,358,196.96	14,615,453,180.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,978,764,916.67)	(10,690,012,072.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	528,106,789.77	547,161,789.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(366,551,284.50)	(426,485,457.60)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>869,174,929.08</b>	<b>868,111,404.06</b>
39301	Програм хангамж	16,213,700.00	16,213,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,238,770.92)	(11,302,295.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	863,200,000.00	863,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>28,425,880,041.64</b>	<b>27,103,853,098.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,040,433,413.12</b>	<b>2,596,708,669.49</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,040,433,413.12</b>	<b>2,596,708,669.49</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>2,040,433,413.12</b>	<b>2,150,204,244.49</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	34,897,277.29	239,216,697.12
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,891,174,715.83	1,873,142,207.37
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>114,361,420.00</b>	<b>37,845,340.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	114,341,420.00	37,825,340.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,000.00	20,000.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>-</b>	<b>446,504,425.00</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого		446,504,425.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>26,385,446,628.52</b>	<b>24,507,144,428.60</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>26,385,446,628.52</b>	<b>24,507,144,428.60</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>4,930,425,368.06</b>	<b>4,930,425,368.06</b>
51101	Өмч: - төрийн	4,930,425,368.06	4,930,425,368.06
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>20,881,958,659.94</b>	<b>19,003,656,460.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	20,881,958,659.94	20,881,958,659.94
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,878,302,199.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	573,062,600.52	573,062,600.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>28,425,880,041.64</b>	<b>27,103,853,098.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,653,418,028.21</b>	<b>18,115,838,487.83</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,053,841,145.21</b>	<b>1,149,695,079.83</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,053,841,145.21</b>	<b>1,149,695,079.83</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,053,841,145.21	1,149,695,079.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,004,997.00	352,221,754.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,517,550,000.00	6,060,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,322,286,148.21	791,413,325.28
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,599,576,883.00</b>	<b>16,966,143,408.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>1,430,469,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,430,469,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>11,599,576,883.00</b>	<b>15,535,673,808.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,599,576,883.00	15,535,673,808.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>16,090,398,959.55</b>	<b>19,985,929,729.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,090,398,959.55</b>	<b>19,985,929,729.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>16,084,811,841.55</b>	<b>19,978,229,729.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>7,769,819,255.44</b>	<b>10,348,450,068.74</b>
210101	Үндсэн цалин	4,302,257,649.66	5,306,799,670.72
210102	Нэмэгдэл	2,710,543,494.66	4,070,658,068.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	205,488,882.10	374,472,544.32
210104	Урамшуулал	551,529,229.02	596,519,785.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>971,791,161.97</b>	<b>1,430,646,342.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	766,755,776.60	1,030,271,606.56
210202	Тэтгэмжийн даатгал	55,466,872.47	99,869,223.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,489,098.12	53,567,590.28
210204	Ажилгүйдлийн даатгал	9,640,889.27	49,367,430.22
210205	Эрүүл мэндийн даатгал	96,438,525.51	197,570,491.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>968,549,037.68</b>	<b>1,414,520,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	165,576,630.68	199,267,010.29
210302	Түлш, халаалт	647,105,189.50	961,790,472.09
210303	Цэвэр, бохир ус	155,867,217.50	253,463,117.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>316,377,242.50</b>	<b>267,552,201.39</b>
210401	Бичиг хэрэг	45,805,630.00	35,444,350.00
210402	Тээвэр, шатахуун	148,096,460.00	139,007,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,259,394.50	4,811,913.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,909,708.00	88,288,777.60
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	21,186,050.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,722,525,387.86</b>	<b>3,837,766,113.11</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,221,122,117.86	3,367,108,693.11
210502	Хоол, хүнс	478,004,270.00	428,513,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,399,000.00	42,143,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>127,392,735.75</b>	<b>144,085,248.77</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,152,985.75	14,681,222.00
210604	Урсгал засвар	83,239,750.00	129,404,026.77

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,201,261.00</b>	<b>36,438,690.00</b>
210702	Дотоод албан томилолт	29,201,261.00	36,438,690.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>85,225,379.00</b>	<b>245,314,678.04</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,786,088.00	212,014,040.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,999,800.00	10,437,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	891,542.00	731,929.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	459,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,156,750.00	19,292,079.00
210807	Газрын төлбөр	886,699.00	838,975.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,093,930,380.35</b>	<b>2,253,455,786.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,310,000.00	4,955,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,080,620,380.35	2,248,500,786.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,587,118.00</b>	<b>7,700,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,587,118.00</b>	<b>7,700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,587,118.00	7,700,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,436,980,931.34)</b>	<b>(1,870,091,241.57)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,850,000.00</b>	<b>8,210,958.35</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,850,000.00	8,210,958.35
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(14,850,000.00)</b>	<b>(8,210,958.35)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,451,830,931.34)</b>	<b>(1,878,302,199.92)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>12,351,052,628.00</u></b>	<b><u>18,544,785,116.30</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,731,554,997.00</b>	<b>358,281,754.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,731,554,997.00	358,281,754.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,731,554,997.00	358,281,754.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,004,997.00	352,221,754.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,517,550,000.00	6,060,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,619,497,631.00</b>	<b>18,186,503,361.75</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	1,430,469,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,430,469,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	10,619,497,631.00	16,756,033,761.75
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,619,497,631.00	16,756,033,761.75
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>12,238,151,591.81</u></b>	<b><u>17,953,623,930.18</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,238,151,591.81</b>	<b>17,953,623,930.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,238,151,591.81</b>	<b>17,945,923,930.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>7,768,278,107.46</b>	<b>10,334,082,866.74</b>
210101	Үндсэн цалин	4,300,716,501.68	5,292,432,468.72
210102	Нэмэгдэл	2,710,543,494.66	4,070,658,068.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	205,488,882.10	374,472,544.32
210104	Урамшуулал	551,529,229.02	596,519,785.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>936,893,884.68</b>	<b>1,226,326,922.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	731,858,499.31	868,053,322.71
210202	Тэтгэмжийн даатгал	55,466,872.47	89,568,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,489,098.12	44,784,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,640,889.27	44,784,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	96,438,525.51	179,136,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>944,377,016.18</b>	<b>1,438,692,621.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	165,576,630.68	194,966,670.29
210302	Түлш, халаалт	633,504,982.00	975,390,679.59
210303	Цэвэр, бохир ус	145,295,403.50	268,335,271.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>214,045,432.50</b>	<b>338,470,713.79</b>
210401	Бичиг хэрэг	26,853,080.00	45,739,800.00
210402	Тээвэр, шатахуун	130,184,800.00	153,924,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,259,394.50	3,856,013.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,628,158.00	134,950,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,242,801,969.99</b>	<b>3,770,648,291.88</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,870,671,969.99	3,139,133,261.88
210502	Хоол, хүнс	345,131,000.00	591,515,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	<b>26,999,000.00</b>	<b>40,000,000.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>102,553,920.00</b>	<b>544,188,245.77</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,600,000.00	368,761,305.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,500,000.00
210604	Урсгал засвар	88,953,920.00	173,926,940.77

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,201,261.00</b>	<b>37,067,690.00</b>
210702	Дотоод албан томилолт	29,201,261.00	37,067,690.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>-</b>	<b>256,446,577.79</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	190,396,050.79
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	34,300,686.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	10,437,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	795,499.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	19,677,712.00
210807	Газрын төлбөр	-	838,975.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>7,700,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>7,700,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,800,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>112,901,036.19</u></b>	<b><u>591,161,186.12</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>355,438,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>355,438,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>355,438,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	355,438,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b><u>(355,438,500.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>112,901,036.19</b>	<b>235,722,686.12</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,911,845.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,911,845.00</b>	<b>598,073,031.12</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,930,425,368.06</b>	<b>573,062,600.52</b>	<b>22,333,789,591.28</b>	<b>27,837,277,559.86</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	22,333,789,591.28	<b>27,837,277,559.86</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,451,830,931.34)	<b>(1,451,830,931.34)</b>
<b>C08</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,930,425,368.06</b>	<b>573,062,600.52</b>	<b>20,881,958,659.94</b>	<b>26,385,446,628.52</b>
<b>D01</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,930,425,368.06</b>	<b>573,062,600.52</b>	<b>20,881,958,659.94</b>	<b>26,385,446,628.52</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	20,881,958,659.94	<b>26,385,446,628.52</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,878,302,199.92)	<b>(1,878,302,199.92)</b>
<b>D09</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,930,425,368.06</b>	<b>573,062,600.52</b>	<b>19,003,656,460.02</b>	<b>24,507,144,428.60</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,479,130,700.00</b>	<b>16,526,154,330.48</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,479,130,700.00</b>	<b>16,526,154,330.48</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,470,442,700.00</b>	<b>16,518,454,330.48</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>11,787,566,300.00</b>	<b>10,334,082,866.74</b>
210101	Үндсэн цалин	5,361,606,200.00	5,292,432,468.72
210102	Нэмэгдэл	5,604,870,400.00	4,070,658,068.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	402,922,400.00	374,472,544.32
210104	Урамшуулал	418,167,300.00	596,519,785.18
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,412,445,800.00</b>	<b>1,226,326,922.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,054,172,200.00	868,053,322.71
210202	Тэтгэмжийн даатгал	89,568,400.00	89,568,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,784,200.00	44,784,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	44,784,200.00	44,784,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	179,136,800.00	179,136,800.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,172,200.00</b>	<b>24,172,021.80</b>
210302	Түлш, халаалт	13,600,300.00	13,600,207.50
210303	Цэвэр, бохир ус	10,571,900.00	10,571,814.30
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>356,092,700.00</b>	<b>338,615,713.79</b>
210401	Бичиг хэрэг	57,403,000.00	45,739,800.00
210402	Тээвэр, шатахуун	153,928,800.00	153,924,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,401,000.00	3,856,013.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,159,900.00	135,095,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>3,844,450,100.00</b>	<b>3,770,648,291.88</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,224,435,900.00	3,139,133,261.88
210502	Хоол, хүнс	580,014,200.00	591,515,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,000,000.00	40,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>549,908,700.00</b>	<b>531,723,245.77</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	378,075,700.00	369,175,805.00
210602	Тавилга	2,333,200.00	1,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	169,499,800.00	161,047,440.77
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>38,333,600.00</b>	<b>36,438,690.00</b>
210702	Дотоод албан томилолт	38,333,600.00	36,438,690.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>457,473,300.00</b>	<b>256,446,577.79</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	383,486,300.00	190,396,050.79
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,000,000.00	34,300,686.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,500,000.00	10,437,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.00	795,499.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,897,000.00	19,677,712.00
210807	Газрын төлбөр	840,000.00	838,975.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,250,000.00	-

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,688,000.00</b>	<b>7,700,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,688,000.00</b>	<b>7,700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,688,000.00	7,700,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18,479,130,700.00</b>	<b>17,115,539,416.30</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>17,915,111,600.00</b>	<b>16,756,033,761.75</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,915,111,600.00	16,756,033,761.75
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>564,019,100.00</b>	<b>359,505,654.55</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	537,781,100.00	352,221,754.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,550,000.00	6,060,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,688,000.00	1,223,900.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,911,845.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>598,073,031.12</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 560,931.6 мянган төгрөгийн 7 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- ЭМДС-аас авах тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэр төрлөөр бүртгэл хөтлөөгүйгүүгээс авлага, урьдчилж орсон орлогыг хооронд нь хааж авлагыг 34,161.2 мянган төгрөгөөр илүү, урьдчилж орсон орлогыг 446,504.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг орлого авахдаа 2,695.1 мянган төгрөгийн өр үүсгэж нягтлан бодох бүргэлийг алдаатай хөтөлсөн;
- Бараа материалд орлогоор бүртгэхдээ өглөг үүсгэн бүртгэсэн боловч мөнгөн хөрөнгө шилжүүлэхдээ өглөгөө хаагаагүй шууд зардалд бүртгэж эмийн өрийг 25,408.0 мянган төгрөгөөр өсгөсөн;
- Мөнгөн хөрөнгийн тайланд орлогыг 482.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн
- Худалдаж авсан 53 нэр төрлийн 47,098.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн;
- Данснаас хассан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг дутуу илэрхийлсэн зэрэг алдааг санхүүгийн тайланд залруулга хийв.

Аудитаар нийт 30,999.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв. тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас төрийн болон албаны нууц хамгаалах ажилтнаар томилогдоогүй 11 албан хаагчид 15,437.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон, оны шилдэг тасаг, ажилтныг шалгаруулж 7,612.4 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын эдийн засгийн ангилал зөрчин олгосон;
2. Түрээсийн орлогын 7,950.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, аккруэл сууриар бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

#### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлагыг дутуу илэрхийлсэн	1	34,161.2			1	34,161.2	1	34,161.2				
УОО-ыг дутуу илэрхийлсэн	1	446,504.4			1	446,504.4	1	446,504.4				
Өглөгийг илүү илэрхийлсэн	3	28,585.5			3	28,585.5	3	28,585.5				
Үндсэн хөрөнгийг зөрүүтэй илэрхийлсэн	2	51,680.5			2	51,680.5	2	51,680.5				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>560,931.6</b>			<b>2</b>	<b>16,368.7</b>	<b>2</b>	<b>16,368.7</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин зөрүүтэй олгосон	1	23,049.4			1	23,049.4						
Авлагыг баталгааж уулаагүй	1	7950.5			1	7950.5						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>30,999.9</b>			<b>2</b>	<b>30,999.9</b>						

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Зөрчил илрээгүй								
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>0</b>						
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Зөрчил илрээгүй								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>0</b>	<b>0</b>						



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 94-ХЭА-2025/137/НА-СТА-ТШЗ  
А 2390049 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн орлогын 7,950.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, аккруэл сууриар бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгадаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн даргын албан албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Бадамсүрэн, нягтлан бодогч Ц.Нарансолонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ

• 232504094



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 95-ХЭА-2025/137/НА-СТА-ТШЗ  
А2390049 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас төрийн болон албаны нууц хамгаалах ажилтнаар томилогдоогүй 11 албан хаагчид 15,437.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон, оны шилдэг тасаг, ажилтныг шалгаруулж 7,612.4 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын эдийн засгийн ангилал зөрчин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдэл, шагнал урамшууллыг үндэслэлгүй олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Бадамсүрэн, нягтлан бодогч Ц.Нарансолонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ

232504093